



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 9/204

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2013 оны "Гадаад байгууллагын төлөөлөгч, иргэнтэй харилцах журам" батлах тухай А/153 дугаар захирамж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны "Нийслэлийн Чингэлтэй дүүргийн гадаад харилцааг хөгжүүлэх бодлогын баримт бичиг батлах тухай" 29, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Чингэлтэй дүүрэг, Бүгд Найрамдах Солонгос Улсын Ёндун-Гүн хошуу хоорондын Найрамдалт харилцааг өргөжүүлэх тухай байгуулсан Санамж бичгийн хүрээнд хоёр талын хамтын ажиллагааг сайжруулах, гадаад харилцааг хөгжүүлэх чиглэлийн дагуу Бүгд Найрамдах Солонгос Улсын Ёндун-Гүн хошуунд газар тариалангийн чиглэлээр улирлын чанартай ажлын байранд зуучлагдах иргэдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Дээрх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлж, тайлан мэдээг тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Д.Уянга)-т үүрэг болгосугай.

3.Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (О.Батмөнх)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010617

Дүүргийн Засаг даргын 2025 онь 06...
дугаар сарын 10-ны өдрийн А/209
дүгээр захирамжийн хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Уянга

Дүүргийн Засаг даргын зөвлөх

Гишүүд:

Г.Хурцбаяр

Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн дарга

Г.Ядамсүрэн

Бүгд Найрамдах Солонгос Улсын
Ёндун-Гүн сумын хамтын
ажиллагааны төлөөлөгч

Б.Билгүүн

Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн
Гадаад харилцаа, хамтын ажиллагаа
хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Л.Баярмаа

Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
хөгжлийн хэлтсийн дарга